

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 7 дугаар сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	2010-VI	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-VII
1	Даатгалын компани	16			16
2	Даатгалын компанийн салбар	136			136
3	Даатгалын төлөөлөгч	2006		5 <sup>1</sup>	2001
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	6			6
6	Актуарч	10			10
7	Аудитын компани	20			20
8	Аудитор	46			46
9	Бусад өөрчлөлт		3 <sup>2</sup>		

Тайлант үед даатгалын компани, тэдгээрийн салбар, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарч, аудитын компани болон аудиторуудын тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны даргын 2010 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 107 дугаар тушаалаар “Нийслэл даатгал” ХХК-ийн 5 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор даатгалын төлөөлөгчийн тоо 2010 оны 7 дугаар сарын байдлаар 2001 болсон байна.

<sup>2</sup>Хорооны даргын 2010 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 109 дүгээр тушаалаар “Прайм женерал даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрч, тус компанийн дүрмийн сангийн 500.0 сая төгрөгийг “Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК, “Петровис” ХХК тус тус 50 хувиар эзэмшиж байна.

<sup>2</sup>Хорооны даргын 2010 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 110 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрч, тус компанийн дүрмийн сангийн 502.0 сая төгрөгийн 7.97 хувийг “Улаанбаатар сан” ХХК, 92.03 хувийг иргэн Ц.Чойбат нар эзэмшиж байна.

<sup>2</sup>Хорооны 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 216 дугаар тогтоолоор “Монгол даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрч, гүйцэтгэх захирлын

үүрэг гүйцэтгэгчээр Т.Батзул, Санхүүгийн газрын захирлаар Ч.Энх-Амгалан нарыг томилохыг зөвшөөрөв.


## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2010 оны 7 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:

### Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		Өөрчлөлт /хувиар/
		2009-VII	2010-VII	
1	Даатгалын нийт хураамж	1,853,989,738.05	2,231,675,654.9	20.3 %
2	Олгосон нийт нөхөн төлбөр	605,909,736.76	342,119,906.1	-43.5 %
3	Давхар даатгалд төлсөн хураамж	33,672,405.97	924,815,304.0	2,646.5 %
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	7,779	7,090.0	
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	99,370,178,559.00	272,890,371,000.0	174.6 %
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	101,790,080.00	23,943,386.3	-76.4 %

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



2010 оны 7 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 377.6 сая төгрөгөөр буюу 20.3 хувиар, давхар даатгалд төлсөн хураамж 891.1 сая төгрөгөөр буюу 2,646.5 хувиар тус тус өсч, олгосон даатгалын нөхөн төлбөр 263.7 сая төгрөгөөр буюу 43.5 хувиар буурсан байна.

Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 46.8 хувь буюу 433.5 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК, 35.6 хувь буюу 329.9 сая төгрөгийг “Бодь даатгал”

ХХК, бусад 17.6 хувь буюу 162.7 сая төгрөгийг “Практикал даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК-иуд шилжүүлсэн байна.

**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

№	Үзүүлэлт	2009-VII	2010-VII	/төгрөгөөр/
				Өөрчлөлт /Хувиар/
1	Даатгалын нийт хураамж	476,246.0	1,819,560.0	282.0 %
2	Олгосон нийт нөхөн төлбөр	540,000.0	2,454,910.0	354.6 %
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	-	
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	12	2	
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд		2	
	-Байгууллагын хугацаат даатгалд		-	
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		-	
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15,000,000.0	1,000,000.0	-93.3 %
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	540,000.0	540,000.0	-

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 7 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 1.3 сая төгрөгөөр буюу 282.0 хувиар, нөхөн төлбөр 1.9 төгрөгөөр буюу 354.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	2010-V	2010-VI	2010-VII	/төгрөгөөр/
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	49,451,418.0	29,465,076.4	31,686,601.0	
2	Даатгалын зуучлагчийн орлого	12,533,780.3	16,515,077.7	13,987,318.7	
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	16	143	302	
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,420,609,952.2	3,009,477,842.0	10,487,981,062.0	

2010 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 302 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучлан 13.9 сая төгрөгийн зуучлалын орлого олж, даатгалын зуучлалын орлого өмнөх сарынхаас 15.3 хувиар буурсан байна.